



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.04.09 № 05/2926.
танай 2019.04.01 -ны № 01/939 -т

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ДЭД ДАРГА
Б.ЗАЯАБАЛ ТАНАА

Нэрлүүлж гаргаж
Бадарцаг
2019/4/9

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн дараах нэр дэвшигчдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно. Үүнд:

1. Татварын ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Энхээгийн Пүрэвдулам,
2. Татварын ерөнхий газрын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн ерөнхий санхүүч, татварын улсын ахлах байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Жаргалсайханы Гэрэлбат,
3. Татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлого, хяналтын газрын татварын хяналт шалгалтын хэлтсийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Дамдинсүрэнгийн Дуламсүрэн,
4. Өвөрхангай аймгийн татварын хэлтсийн Татварын орлогын тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Равданжамцын Наранчулуун.

Нэр дэвшигчид нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж уг хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гарган ажиллах нь зүйтэй.

Харин нэр дэвшигч Ж.Гэрэлбат нь шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3. ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх." гэж заасан тухайн албан тушаалд тавих тусгай шаардлагыг хангаагүй байх тул шаардлагад нийцсэн этгээдийг нэр дэвшүүлэн томилоход анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

[Handwritten signature]



[Handwritten signature] Х.ХАШБААТАР

[Handwritten signature]